

## ХӨХ ХОТЫН ХӨГЖИЛТИЙН ТУХАЙ ӨГҮҮЛЭХ НЬ

*Н.Улаан-Од\**

ӨМӨЗО-ы улс төр, эдийн засаг, соёлын төв Хөх хот нь Хятадын баруун бүс нутгийг нээн хөгжүүлэх стратегийн хүрээнд чухал гол хотын нэгэнд ордог. ӨМӨЗО-ы дунд хэсгийн Түмэдийн тэгш газар, хойт талаараа Далан хар уулыг түшиж, урьд биеэрээ Хатан голыг хөвөөлж, нийслэл Бээжингээс 500 гаруй км зайтай, боомтын хот Эрзэнээс 490 гаруй км зайтай, баруун хойт муж, район болон дотор газрыг хуурай боомгоор холбосон гарц газар төдийгүй Хятадын дотор газар болон Монгол улс, Орос, Европын улсуудыг холбосон гүүр юм. Хотын нийт талбай нь 17224 ам метр, Юй Чүань, Хотон, Шинэ хот, Сайхан зэрэг 4 дүүрэгтэй, Түмэд зүүн хошуу, Ү Чүань, Хорин гэр, Чин Шүйхэ, Тогтох сянь гэсэн 5 хошуу сяньтай. Нийт 2.09 сая хүн амтай, үүнд хот дүүргийн хүн ам нь 1.06 сая, бүх хотын үндэстний цөөнхийн хүн ам 250 мянга, үүнээс монгол үндэстэн 188 мянга.

Хөх хот нь цаг агаарын байршлын хувьд дунд дулаан бүслүүрийн доод бүсэд оршдог бөгөөд баруун хойтын эх газрын хуурай цаг агаарт нөлөөтэй, далайн түвшнөөс 1050 метрт байдаг тул зундаа хэт халуунгүй, өвөлдөө тэсгим хүйтэнгүй, дөрвөн улирал нь тодорхой ялгаатай.

Хил хязгаарын нээлттэй хотын нэгд ордог Хөх хот нь дэлхийн 26 улс, бүс нутагтай олон талт эдийн засаг, техникийн хамтын ажиллагаа, хэлхээ холбоотой.

Сүүлийн жилд, Хөх хот нь тариалан, хөдөө тосгоны эдийн засгийн бүтцийг өөрчлөхийг гол болгосон, ядууралыг бууруулж чинээлэг амьдралын түвшинд хүрэх стратеги, аж үйлдвэрийн эдийн засгийн бүтцийг зохицуулахаар чухалчилсан хотын эдийн засгийг хөгжүүлэх стратеги, хотын цогц хүчин чадал, боловсон байдлыг дээшлүүлэхээр гол болгосон орчин үеийн хот бүтээн байгуулах стратегийг хэрэгжүүлж, улс ардын аж ахуй болон нийгмийн олон талт үйлс нь тасралтгүй хөгжиж, одоо улсын гадаад, дотоодын

\* Н.Улаан-Од - Өвөр Монголын их сургуулийн хөрш орныг судлах хүрээлэн

хөрөнгө оруулагчдын сэтгэлд нийцсэн хөрөнгө оруулах районы нэг болжээ. Хятадын баруун бүс нутгийг нээн хөгжүүлэх стратегийн хэрэгжилт нь Хөх хотын шинэ хөгжилд нэн чухал ач холбогдолтой бөгөөд Хятадын хойт хилд цоо шинэ Хөх хот сүндэрлэн босч байна.

### ТҮҮХ, СОЁЛ

Хөх хот нь өнө удаан эртний түүх, элбэг баялаг соёлын улбаатай. Олоогоос 500 мянган жилийн өмнөх (Да Яаогийн соёл)- нь Хөх хотын хүн ардын боловсон түүхийг гэрчилж байх юм. Байлдаант улсын үеэс хот байгуулж ирсэн түүх нь нэгэнт 2000 гаруй жил болжээ. Тэр үед Жао Үлин ван одоогийн Тогтох сяньд (Юй Жүн) хотын суурийг эхэлж тавьсан нь Хятадын түүхэнд хамаг эртний феодалын хотын нэг болжээ. Одоогийн Далан хар уулын хормойгоор байгаа балагас хотын буурь нь хүмүүст Жао Үлин вангийн Түмэдийн өргөн талд хот байгуулж байсан үүх түүхийг санагдуулдаг. 1572 онд Алтан хаан, Хөх хотын Юй Чүань дүүрэгт хот байгуулж эхэлснээр одоогийн хотын дүр төрхийг буй болгосон бөгөөд дараа нь үүний суурь дээр Чин улсын үед хотыг өргөтгөн барьж, (Сүй Юань) хот гэж бас нэрлэж, Хятадын хойт хилийн цэргийн явдлын чухал бааз, худалдааны төв болгожээ. Хөх хот нь Хатан голын дунд урсгалын дээд талд оршиж байдаг. Хүннү, Сяньби, Тү-жүе, монгол зэрэг умардын олон үндэстэнүүд хамтаар энэхүү эртний домогт нутагт эв найртай аж төрж амьдарч иржээ. Үүний дагуу тал нутгийн соёлыг бүрдүүлж, Жао Зюнь соёлоор онцлог болгож, орчин үеийн нийслэлийн соёлыг төлөвшүүлсэн нь өнөөдөр Да Яаогийн соёл, Мони уулын хадны зураг, Хорин гэрийн Хань улсын үеийн онгоны хананы зураг, Жао Зюний онгон, Ляо улсын үеийн цагаан суварга, Их зуу хийл зэрэг түүх соёлын дурсгалт зүйлүүд нь Хөх хотын түүхт соёлын өнө эртний түүхэн байдлыг тод харуулж байгаа юм.

### ЭДИЙН ЗАСАГ

Сүүлийн жилүүдэд, Хөх хот нь эдийн засгийн бүтээн байгуулалтын хурдацаа түргэтгэж, орчин үеийн хот байгуулахын төлөө, Хятадын баруун бүс нутгийг нээн хөгжүүлэх стратегийг хэрэгжүүлэн хөгжүүлэх бодлогыг баримталснаар аж үйлдвэр, хөдөө аж ахуй, худалдаа үйлчилгээний салбарыг зохицуулан хөгжүүлж

маш их амжилт олсон байна. 1995 оноос нааш, дотоодын үйлдвэрлэлийн нийт хэмжээ жилд дунджаар 11.3 хувиар, аж үйлдвэр, хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүний хэмжээ жилд дунджаар 16 хувиар, санхүүгийн орлого жилд дунджаар 16.5 хувиар, нийгмийн үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын нийт хэмжээ жилд дунджаар 15 хувиар, нийгмийн хэрэглээний жижиглэн худалдаалах нийт хэмжээ жилд дунджаар 10 хувиар өсчээ. 2000 онд дотоодын үйлдвэрлэлийн нийт хэмжээ 17.925 тэрбум юань, нэг хүнд ногдох дотоодын үйлдвэрлэлийн нийт хэмжээ 8478 юань, санхүүгийн орлого 2.045 тэрбум юаньд хүрчээ. Хотын хүн амд ногдох мөнгөн орлого 5582 юань, хөдөөгийн хүн амд ногдох цэвэр мөнгөн орлого 2538 юаньд хүрчээ.

### 1. АЖ ҮЙЛДВЭР

Хөх хот нь ӨМӨЗО-ы чухал аж үйлдвэрийн хот болох юм. Ноосон нэхмэл, хувцас, электрон хэрэгсэл, машин техник, эрчим хүч, хүнсний бүтээгдэхүүн, химийн үйлдвэр, барилгын материалаар гол болгосон, төрөл зүйл нь нэлээд бүрдсэн боловсруулах хөнгөн үйлдвэрийн системийг бүрэлдүүлжээ. Сүүлийн жилүүдэд аж үйлдвэрийн эдийн засгийн бүтцийг зохицуулахад мэдэгдэм амжилт олж байна. 2000 онд Хөх хотын аж үйлдвэрийн нэмэгдэл өртгийн хэмжээ 6.53 тэрбум юаньд хүрч, И Ли корпораци, Үндэстэн корпораци, Жинь Юй корпораци, Чи Жи корпорациуд нь Хятадын том групп компаний эгнээнд орсон юм. И Ли корпораци болон Чи Ши корпораци нь ноос ноолуурын баялаг болон шинэ техникийн хүчнийг ашиглан, өөрийн гэсэн Хятадын нэрт бүтээгдэхүүнийг бүтээсэн юм. Төрийн өмчит аж ахуйн нэгжийн өөрчлөн байгуулалтыг эрчимжүүлэхийн дагуу, Хөх хот нь хувь хүн хамт нийтэд ашигтай эдийн засгийг хөгжүүлэх иж бүрэн төрийн бодлого хэрэгжүүлснээр эдгээр салбарын хөгжилт нь эрчээ авч байна. 2000 оны сүүлчээр, хувийн хэвшлийн наймаачид 440 мянган өрх, амины аж ахуйн нэгж 6998 болж, эдгээр салбараас нийт 3 тэрбум юаний эдийн засгийн үр ашиг олжээ.

### 2. ХӨДӨӨ АЖ АХУЙ

Хөх хот нь өргөн уудам дэвсгэр нутаг, үржил шимт хөрс шороо, элбэг баялаг ус булагтай тул хөдөө аж ахуйг хөгжүүлэх

давуу нөхцөлтэй юм. Одоо тариалах талбай нь 560 мянган га, үүнд услаж болох талбай нь 159.25 мянган га байж, улаан буудай, шар будаа, эрдэнэ шиш, хөх тариа, юү май зэргийг тариалж, ургацын хэмжээ жилд бараг 800 мянган тоннд хүрч байна. 2000 онд хөдөө аж ахуйн нэмэгдэл өртөг 2.501 тэрбум юаньд хүрчээ. Өвөр Монголын Хуа Мэн алтан гол корпораци нь эрдэнэ шишийг ашиглан амьд бодисоор исгэх орчин үеийн технологийг хэрэглэж амжилтад хүрснээр бордоон тэжээлээр эм хийх дэлхийн хамгийн том үйлдвэр байгуулсан юм. Улсаас баруун бүс нутгийг нээн хөгжүүлэх стратегийн хүрээнд, Хөх хот нь хөдөө аж ахуй, хөдөө тосгоны эдийн засгийн бүтцийг зохицуулах явцдаа, боломжтой бүхнийг бүрэн ашиглаж, зах зээлээр хандлага болгож, тариалахаа зогсож өвс мод тарих хөдөлгөөн буй болгож байна. 2000 онд тариалахаа зогсож, өвс мод тарьсан талбай нь 350 мянган му \1 му - 15 гектар\ байж, бас гадаадаас шилдэг өвс модны үр оруулахын дагуу орон нутгийнхаа байдалд зохицуулж \Цагаан идээний зах\ -ыг байгуулахаар төлөвлөж байх тул сүүний үйлдвэрлэл урьд гараагүй хөгжиж эхэллээ. Одоо сүүний үнээ 91.5 мянган толгой байж, 230 мянган тонн сүү сааж, хүн бүрд ногдох сүүн бүтээгдэхүүний дундаж хэмжээ бүх улсын том дунд зэрэглэлийн хотын дотор тэргүүн байрт орж байна.

### 3.ХУДАЛДАА

Хөх хот нь ӨМӨЗО-ны худалдааны төв хотын хувьд, хот хөдөөг холбосон, орны дунд баруун хэсэгт нөлөөлсөн, дотор газар болон Монгол улс, Оросын худалдааны сүлжээг нийлүүлсэн байдлыг буй болгож чаджээ. Өвөр Монголын үндэстний корпораци, Тянь Юань их дэлгүүр, Шинэ эрин их дэлгүүр, Бай Шэн их дэлгүүр зэрэг нэг бүлэг орчин үеийн худалдаа наймааны аж ахуйн нэгжийг байгуулж, зах зээлийн системийг өдөр ирэхүйе төгөлдөржүүлж, төрөл бүрийн худалдааны цэг, хоол ундааны цэгийг 30 мянга хүртэл байгуулж, 2000 онд нийгмийн таваарийн жижиглэн худалдааны нийт хэмжээг 6.949 тэрбум юаньд хүрчээ.

### 4.ГАДААДАД НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ

Хөх хот нь Төрийн Зөвлөлөөс тогтоосон хил хязгаарын нээлттэй чухал хот болох юм. Хөх хотын эдийн засаг нийгмийг

бүх талаар хөгжүүлэхийн төлөө Хөх хотын гадаад дотоодтой харилцаа холбоо, техникийн хамтын ажиллагаа, соёл урлагийн солилцоо өдөр ирэхүйе өргөжин тэлж, гадагш нээлттэй хөгжих байдлыг буй болгож, бүх талаар нээн ашиглах нээлттэй байх шинэ хандлагыг бүрдүүлжээ. 2000 оны эцэс хүртэл, Хөх хот нь дэлхийн 26 улс болон бүс нутагтай эдийн засаг техникийн хамтын ажиллагааны харилцаа байгуулж, 1985 оноос нааш гадаадын хөрөнгө оруулалттай 162 төслийг хэрэгжүүлж, 133 сая долларын гадаадын хөрөнгө оруулалтыг үр ашигтайгаар ашиглажээ. Үүний дагуу улсын дотоодын бусад ӨЗО, муж, хотын районтай эдийн засгийн хамтарсан төсөл хэрэгжүүлж илтэд амжилт олж, улсын дотоодын 29 хоттой ах дүү хот бололцож, 40 гаруй хот болон районтай эдийн засгийн хамтын ажиллагаа тогтоожээ.

## ХОТ БАЙГУУЛАЛТ

### 1.ХОТЫН ДЭД БҮТЭЦ

Сүүлийн жилүүдэд, Хөх хот нь улсаас баруун бүс нутгийг нээн хөгжүүлэх хүрээнд хотын дэд бүтцийн бүтээн байгуулалтын хүчийг эрчимжүүлж, хотын цогц үйлчилгээний хүчин чадлыг мэдэгдэм нэмэгдүүлж, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулж, хотын бусад салбарыг дагалдуулан хөгжүүлж, хот хөдөө холбоолсон байдлыг буй болгожээ. Одооны байдлаар, хотын нийтийн замын урт нь 414.9 км, хотын ногоон талбай нь 59.2 мянган ам метр, өдөрт ус түгээх хүчин чадал нь 383 мянган тонн, өдөрт бохир ус гадагшлуулах хүчин нь 280 мянган тонн, шатдаг хийн хангалт нь 69.77 хувь, хүн бүрд ногдох орон суушын талбай нь 9.27 ам метрт хүрчээ.

### 2.ЗАМ ХАРИЛЦАА ХОЛБОО

Хөх хот нь хятадын дотор газар болон Монгол улс, Оросыг холбосон чухал зам харилцааны уулзвар газар төдийгүй хятадын 45 гол авто замын зангилаа хотын нэг юм. Бээжин болон баруун хойт орныг холбосон улсын зэрэглэлийн 110-р зам болон Бээжин Ланьжоуг холбосон төмөр зам нь үүгээр өнгөрч байх юм.

Өдөрт 23 хос галт тэргээр зорчигчид зөөж байдаг. Одоо

өргөтгөн барьж байгаа Хөх хот - Бугатын өндөр хурдын авто зам болон шинэчлэн барьж байгаа Бээжин - Хөх хотын өндөр хурдын авто зам ашиглалталд орох гэж байгаа нь Хөх хотын дотор газруудтай өргөнөөр харилцах үйл хэрэгт маш дөхөм үзүүлэх болно. Одоо 2 зурвас Олон улсын агаарын шугам, 50 гаруй зурвас улсын дотоодын агаарын шугамыг ажиллуулж байна. Мэдээллийн хөгжилт нэн их хурдацтай байж, телефон утасны нийт тоо нь 500 мянган өрхөд хүрч, хот хөдөөгийн зуун хүний 14 нь телефон утастай болсноор барахгүй, гар утас болон бусад холбооны сүлжээ үйлчилгээ өдөр ирэхүйе сайжирч байна.

### 3. ЭМНЭЛЭГ ЭРҮҮЛ ХАМГААЛАЛ

Одооны байдлаар Хөх хот нь хот, хошуу, сян, дүүрэг болон сум гацааны эм эмнэлэг, эрүүл хамгааллын урьдчилан сэргийлэх сүлжээг буй болгож, бүх хотдоо эм эмнэлэг эрүүл хамгааллын 199 байгууллага, эмнэлгийн өвчтөний ор 7441, эрүүл хамгааллын эмч мэргэжилтэн 10.9 мянган хүнтэй болжээ. Хөдөө тосгонд эмнэлгийн 1000 гаруй цэгтэй, сум гацаанд 2000 гаруй эмчтэй, тосгоны эмнэлгийн цэгийн тархалт нь 95 хувьд хүрсэн байна.

### 4. ЭКОЛОГИЙН ОРЧИН

Хөх хот нь Хятадын умарт хэсгийн экологийн орчныг хамгаалах чухал газар болох бөгөөд Хатан голын дунд дээд урсгалын дагуу мод тарьж ногооруулах төслийг хэрэгжүүлэх төв район болно. 1999 онд Хөх хот нь байгаль орчин, хот байгуулах ерөнхий шаардлагыг дурдан гаргаж, 10 жилийн дотор Хөх хотыг экологийн цэвэр хот болгон бүтээн байгуулахаар төлөвлөж байна. Хойшид ой модны талбайг 4.4195 сая му-гаар \1 му нь 15 гектар\ нэмэгдүүлэн тарьж, одоогийн ой модны бүрхэцийн 17.48 хувийг, 27.38 хувь болгон дээшлүүлж, тариалаахаа зогсож, өвс мод тарих талбайг 2.637 мянган му болгон нэмэгдүүлэх, ус хөрс эвдэгдсэн 770 км<sup>2</sup> талбайг засах, хотын хүн бүрд ногдох ногоон талбайг 8 м<sup>2</sup> болгох, сум гацааны замын хажуу, тариалангийн талбай 8 м<sup>2</sup> болгох, сум гацааны замын хажуу, тариалангийн талбайн дэргэдэх ойжуулалтын талбайг 85 хувьд хүргэх, гацаа тосгоны ойжуулалтын хэмжээг 20 хувиас дээш байлгахад төлөвлөн ажиллаж байна.

## НИЙГМИЙН САЛБАР

### 1. ШИНЖЛЭХ УХААН, БОЛОВСРОЛ

Хөх хот бол Улсын шинжлэх ухаан боловсролыг түргэн хөгжүүлэх туршилтын хот болно. Одоо 104 шинжлэх ухааны байгууллагад 90 мянган эрдэм шинжилгээний ажилтан ажилладаг нь ӨМӨЗО-ны шинжлэх ухааны салбарынхны 30 илүү хувийг эзэлж байна.

2000 онд хот дүүрэгт 9 их дээд сургуульд, 44 мянган оюутан сурч, 84 дунд сургууль, дунд зэргийн тусгай мэргэжлийн сургууль, арван жилийн мэргэжлийн дунд сургуульд 63 мянган оюутан, 134 энгийн дунд сургуульд 1150 мянган оюутан, 879 бага сургуульд 206 мянган сурагч сурч байгаагаас бүрийн насанд хүрэгчдийн гадна төрөл боловсролын систем төгөлдөржин олширч байна. Үндэстний цөөнхийн ӨЗО-ны хувьд үндэстний боловсролыг нэн илүү чухалчлан тэргүүн байрт хөгжүүлж байна. Бүх хотод үндэстний 12 дунд сургууль, 11 мянган сурагч, үндэстний 36 бага сургуульд, 13 мянган сурагч суралцаж байна. Хүүхдийн цэцэрлэг, бага сургууль, энгийн дунд сургууль болон мэргэжлийн дунд сургуулиас өгсүүлээд бүх шатанд шинэ боловсролын систем бүрэлдэн тогтож байна. 2000 онд бүх хотод биеийн тамир спортын ордон, зал, талбай 1500 бий бөгөөд үүнд Азид хамгийн томд орох Өвөр Монголын морин тойруулгын талбай болон орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон Хөх хотын биеийн тамир спортын ордон хамрагдаж байх юм. Биеийн тамирын хөдөлгөөний цар хэмжээ ч ихээр дээшлэж, зарим тамирчид бүх улсын буюу дэлхийн шилдэг амжилт тогтоосон юм.

### 2. СОЁЛЫН САЛБАР

Сүүлийн жилүүдэд, Хөх хот нь орчин үеийн хот байгуулалтыг эрчимжүүлж, соёлын барилга байгууламжийг тасралтгүй байгуулж байна. Бүх хотод саян зэрэглэлийн 10 гаруй номын сан, 2 сая ширхэг ном хадгалагдаж байна. Кино театр, соёлын ордон болон урлагийн ордон 30 гаруй, соёлын цэг 50 гаруй байж, мэргэжлийн урлагийн бүлгэм 15 байна. Түүх соёлыг хамгаалах ажлыг эрчимжүүлснээр 2000 онд Хөх хот нь Мин, Чин гүрний үед



барьсан эртний барилга байгууламжийг засварлан сэргээж, түүнийг хамгаалах олон талт арга хэмжээ авч, өнгө үзэмжийг шинэтгэн босгож байна. Хэвлэл мэдээлэл радио телевизийн үйлс ч үтэр түргэн хөгжиж байна. Одоо \Хөх хотын өдрийн сонин\ \Хөх хотын оройн сонин\ Хөх хотын телевизийн хороо, Хөх хотын кабелийн телевизийн хороотой болж, эдгээр байгууллага нэгж нь өргөн олон уншигч, сонсогч, үзэгчидтэй болж байна.

## АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Хөх хот нь ӨМӨЗО-ны аялал жуулчлалын төв хот юм. Байгалиас хүртээсэн хэдэн мянган жилийн түүхтэй соёлын өгөөж болон эх байгалийн өнгө үзэмж нь гадаад дотоодод алдартай юм. Үндэстний нэгдэл нягтралын бэлэгдэл болсон Жао Зюний онгон нь умартын үндэстнүүдийн эв найрамдалтай, эвсэг дотно аж төрж, хамтаар хөгжиж ирсэн түүхийг үнэн бодиттойгоор харуулж, Их зуу, Ширээт зуу, Устын зуу зэрэг сүм хийд нь уул төрхөөрөө байж, Хөх хотын өнө удаан түүхийн бодит тэмдэглэл нь болж, Далан хар уулын Устын ой шугуйн парк нь умарт орны уул усны өнгө үзэмжийн сүрлэг сайхныг үзүүлж, \Боомтын гаднах Ши Ху нуур\ нэртэй Ха Су хай нуур нь өмнө орны цэвэр тунгалаг өнгө үзэмжтэй газруудын адил жуулчлалын халуун цэг болж байна. Сүүлийн жилүүдэд, Хөх хот нь аялал жуулчлалын үйлсийг ихээр хөгжүүлж байна. Одоогийн байдлаар, таван одтой нэг, дөрвөн одтой зочид буудал тус бүр нэг, гурван одтой зочид буудал тав, хоёр одтой зочид буудал 6 ажиллаж, 2000 онд 2,08 сая гадаад дотоодын жуулчлагчдыг үлээн авч үйлчилсэн бөгөөд 3 сая ам долларын гадаад валют олж, нийт 3.4 тэрбум юаний ашиг орлого олсон байна.